



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар A/449

Улаанбаатар хот


Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “YAMAT-08”-ын тухай 1/1824 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д Эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн жагсаалт, холбогдох код/индексийг шинэчлэх, шинээр нэмэх, өөрчлөх, хүчингүй болгох талаар санал боловсруулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, комиссын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны “Аргачлал батлах тухай” А/119 дүгээр тушаалыг мөрдөж ажиллахыг Комиссын дарга /Б.Цогтбаатар/-д үүрэг болгосугай.

САЙД




Д.САРАНГЭРЭЛ

2019-A-tushaal

081723


Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дугаар сарын 20-ний өдрийн А/449
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Комиссын бүрэлдэхүүн

- Комиссын дарга: ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, нийгмийн баталгааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
- Гишүүд:
- ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
 - Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
 - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын албаны дарга
 - ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Улсын гуравдугаар төв эмнэлгийн Ерөнхий захирал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дугаар сарын 30-ний өдрийн А/Н/49
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Комиссын ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1 Комисс нь үйл ажиллагаандаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны "Аргачлал батлах тухай" А/119 дүгээр тушаалыг мөрдөж ажиллана.

Хоёр. Комиссын чиг үүрэг

2.1 Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс ирүүлсэн эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилалыг шинэчлэх, шинээр нэмэх, өөрчлөх, хүчингүй болгох саналыг цахим болон албан бичгээр хүлээн авч, тэдгээрт хамаарах ажлын байрны тодорхойлолт, үндсэн чиг үүргийг судална.

2.2 Комисс нь ангилалд нэмэлт, өөрчлөлт хийх, шинэчлэх, шинээр нэмэх, хүчингүй болгох талаар ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс ирүүлсэн санал, тэдгээрт хамаарах ажлын байрны тодорхойлолт, үндсэн чиг үүргийг судалж үзсэний үндсэн дээр үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт -08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, шинээр нэмэх саналыг маягтын дагуу шинэчлэн ажил мэргэжлийн нэр тус бүрээр боловсруулж хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад эхний хагас жилд багтаан хүргүүлнэ.

2.3 Ажил, мэргэжлийн ангиллын цахим хувилбарыг мөрдүүлэх, шинэчлэгдсэн хувилбаруудыг тухай бүр хөтөлж, олон нийтэд мэдээллэнэ.

Гурав. Комиссын үйл ажиллагаа

3.1. Комиссын ажиллах хэлбэр нь хурал байна. Хурлыг комиссын дарга удирдана. Комиссын гишүүдийн 70-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хурлыг хүчин төгөлдөрт тооцно.

3.2. Хурлын шийдвэр нь зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хүчинтөгөлдөр болно.

3.3. Комиссын дарга нь хурлын хөтөлбөрийг баталж, хурлын тэмдэглэлийг хянах, хурлын шийдвэрт гарын үсэг зурж баталгаажуулах эрхтэй.

3.4. Нарийн бичгийн дарга комиссын даргын баталсан хурлын хөтөлбөр, хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулгыг гишүүдэд хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө цахим эсхүл цаасан хэлбэрээр хүргүүлсэн байна.

3.5. Нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэл хөтөлнө.

3.6. Нарийн бичгийн дарга нь хурлын шийдвэрийн дагуу үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт -08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, шинээр нэмэх, хүчингүй болгох саналыг энэ журмын хавсралтын 2.2-д заасан байгууллагад хүргэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

3.7. Нарийн бичгийн дарга нь Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс ирүүлсэн эрүүл мэндийн салбарын ажил, мэргэжлийн ангилалыг шинэчлэх, шинээр нэмэх, өөрчлөх, хүчингүй болгох саналын мэдээллийн санг хөтлөнө.

3.8. Нарийн бичгийн дарга нь хуралд саналын эрхтэй оролцоно.